



ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 01 сарын 30 өдөр

Дугаар 09

Эрдэнэт

Ээлжит хуралдаан зарлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1, 23 дугаар зүйлийн 23.4 дэх хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 7 дахь удаагийн сонгуулийн бүрэн эрхийн хугацааны Ээлжит V хуралдааныг 2017 оны 02 дугаар сарын 17-ны өдөр Эрдэнэт хотод зарлан хуралдуулж, дараах асуудал хэлэлцүүлэхээр тогтоосугай.

1. Боловсролын салбарыг 2014-2016 онд хөгжүүлэх хөтөлбөрийн биелэлт, 2017-2020 онд хөгжүүлэх хөтөлбөр батлах тухай

2. Аймгийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих журмын хэрэгжилтийн явц байдал, цаашид авах арга хэмжээний тухай

3. “Эрдэнэтчүүд Эрдэнэтчүүддээ хайртай” дэд хөтөлбөр батлах тухай

4. Хог хаягдлын үнэ, тарифыг шинэчлэн тогтоох тухай

5. Шилжих үлдэгдлээс зарцуулах хөрөнгийн тодотгосон төсөв батлах тухай

6. Бусад

Хоёр. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит V хуралдааны бэлтгэл хангах арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтын ёсоор баталсугай.

Гурав. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит V хуралдааны бэлтгэл хангаж хуралдуулахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга П.Пүрэвлхагвад даалгасугай.

ДАРГА  П.ПҮРЭВЛХАГВА



C:\Togtool \-A4 doc

00100435